

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/94/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нарантуул Гэрээт аудитор: Б.Бадамцэцэг Утас: 70432545</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
АОУС	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
УСНББОУС	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
ТТЗ	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
Т	
ШЗ	<i>Төсвийн шууд захирагч</i>
	<i>Санхүүгийн тайлангийн аудит</i>
СТА	
ХХААГ	<i>Хүнс Хөдөө аж ахуйн газар</i>
ХХОАТ	<i>Хувь хүний орлогын албан татвар</i>
НДШ	<i>Нийгмийн даатгалын шимтгэл</i>

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3. Аудитын тайлан	14
3.1. Ерөнхий зүйл	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	15
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	17
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Залруулсан алдаа	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	
Аудитын зөвлөмж	20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	20
4. Менежментийн захидал	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХҮНС,ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
ДАРГА Б.БЯМБАЖАВ ТАНАА

2021.02.25 № 2/100
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Шилмэл мал хөтөлбөрийн хүрээнд Аймгийн Засаг даргын А/193 тоот захирамжаар "Герефорд" үүлдрийн өсвөр хээлтүүлэгч 148000.0 мянган төгрөгөөр худалдан авахдаа тендер зарлаагүй, шууд гэрээ байгуулсан, үржлийн мал амьтныг хөрөнгөд бүртгээгүй, тээвэр, шатахууны зардал болон бусад зардлыг өртөгт шингээж бүртгээгүй, мөн Сэлэнгэ үүлдрийн үнэ төлбөргүй ирсэн хээлтүүлэгчийг холбогдох удирдах албан тушаалтны шийдвэргүйгээр сумдад хуваарилан олгосон, өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, авлага барагдуулаагүй, өсгөсөн, шатахууны орлого, зарцуулалтын тооцоо бодоогүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8 –д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 6.4.2-д "төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх" 6.4.4-д хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох заалтуудыг, 24.4-д " төсвийн

021020571

хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", УСНББОУС 17-д 31.а-д Үндсэн хөрөнгийн барьж байгуулах буюу худалдан авахтай шууд холбогдон гарсан зардал, б.-д газар талбайг бэлтгэх зардал, в-д анхны хүргэлт ба ачиж буулгах зардал, г-д суурилуулалт ба угсралтын зардал үндсэн хөрөнгийн өртөгт орно, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27.1. Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр концессийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 7.1-д Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна: 7.1.1.нээлттэй тендер шалгаруулалтын журам; 7.1.2.тендер шалгаруулалтын онцгой журам; гэж заасныг тус тус зөрчиж аудитын "Оршин байх", "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг", "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>617,498,850.65</u>	<u>655,383,976.74</u>
33	АВЛАГА	547,907,434.07	558,731,515.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	392,159.54	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2,693,759.53	5,650,000.00
335	Бусад авлага	544,821,515.00	553,081,515.00
3351	Байгууллагаас авах авлага	544,821,515.00	553,081,515.00
35	БАРАА МАТЕРИАЛ	69,591,416.58	96,652,461.74
351	Түүхий эд материал	15,207.36	304,000.00
35110	Тусгай зориулалттай материал	-	304,000.00
35130	Эм боох материал	15,207.36	-
354	Хангамжийн материал	57,607,209.22	84,498,461.74
35410	Бичиг хэргийн материал	943,800.00	899,700.00
35420	Аж ахуйн материал	50,395,606.82	80,086,459.34
35430	Сэлбэг хэрэгсэл	287,500.00	286,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,250,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	3,730,302.40	3,226,302.40
35600	Мал амьтад	11,969,000.00	11,850,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>532,732,373.20</u>	<u>477,563,579.18</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	532,732,373.20	477,563,579.18
392	Биет хөрөнгө	422,157,673.26	366,638,879.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	86,060,080.00	86,060,080.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,075,751.10)	(2,510,085.90)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	254,453,527.00	254,453,527.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(120,562,069.95)	(153,170,755.83)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	112,740,835.43	112,740,835.43
39206	Хуримтлагдсан элэгдэл	(95,871,788.30)	(100,223,815.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,601,305.76	18,601,305.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,989,180.76)	(14,080,055.37)
39214	Бусад үндсэн хөрөнгө	258,432,623.46	270,932,623.46
39215	Хуримтлагдсан элэгдэл	(78,156,321.53)	(106,689,193.16)

39217	Ном	524,413.25	524,413.25
393	Биет бус хөрөнгө	110,574,699.94	110,924,699.88
39303	Бусад биет бус хөрөнгө	111,099,700.00	112,199,700.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(525,000.06)	(1,275,000.12)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,150,231,223.85</u>	<u>1,132,947,555.92</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>635,100.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	635,100.00
413	Өглөг	-	635,100.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	117,000.00
4136	Бусад өглөг	-	518,100.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	518,100.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,150,231,223.85</u>	<u>1,132,312,455.92</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,150,231,223.85	1,132,312,455.92
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,175,118,077.35	1,175,118,077.35
51101	Өмч: - төрийн	1,175,118,077.35	1,175,118,077.35
512	Хуримтлагдсан үр дүн	(114,205,488.39)	(132,124,256.32)
51210	Өмнөх үеийн үр дүн	689,468,213.74	(114,205,488.39)
51220	Тайлант үеийн үр дүн	(803,673,702.13)	(17,918,767.93)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	89,318,634.89	89,318,634.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,150,231,223.85</u>	<u>1,132,947,555.92</u>

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН/ /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	570,103,943.02	664,070,262.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	73,963,533.02	109,565,189.90
120	Нийтлэг татварын бус орлого	73,963,533.02	109,565,189.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	73,963,533.02	109,565,189.90
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	73,963,533.02	109,565,189.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	496,140,410.00	554,505,072.37

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	313,766,300.00	382,252,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	313,766,300.00	382,252,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	182,374,110.00	172,252,772.37
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	88,876,900.00	163,650,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	82,288,400.00	3,663,772.37
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,208,810.00	4,939,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	731,756,450.53	681,989,030.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	731,756,450.53	681,989,030.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	696,451,359.53	650,381,767.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	165,925,274.19	196,198,113.35
210101	Үндсэн цалин	147,428,267.19	195,360,239.07
210102	Нэмэгдэл	14,813,807.00	350,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,683,200.00	487,874.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,512,340.46	23,741,903.00
210201	Тэтгэврийн даатгал	13,142,840.46	16,400,014.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,592,400.00	2,014,778.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,273,900.00	1,649,256.00
210204	Ажилгүйдлийн даатгал	318,500.00	333,588.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,184,700.00	3,344,267.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,616,509.00	10,035,303.00
210301	Гэрэл, цахилгаан	1,649,529.00	671,243.00
210302	Түлш, халаалт	8,786,980.00	9,279,060.00
210303	Цэвэр, бохир ус	180,000.00	85,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	78,236,320.20	68,067,281.38
210401	Бичиг хэрэг	4,117,783.80	1,113,200.00
210402	Тээвэр, шатахуун	21,547,760.00	16,009,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,256,623.00	1,469,444.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,240,241.06	49,475,037.38
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	44,073,912.34	
2105	Нормативт зардал	9,718,200.43	15,207.36
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,673,300.43	15,207.36
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	44,900.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	82,872,907.69	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	74,986,007.69	
210604	Урсгал засвар	7,886,900.00	
2107	Томилолт, зочны зардал	7,526,900.00	3,013,800.00
210702	Дотоод албан томилолт	7,526,900.00	3,013,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	194,168,162.08	278,318,065.07
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	193,289,462.08	277,094,381.07
210803	Даатгалын үйлчилгээ	420,700.00	532,664.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	425,000.00	234,420.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	390,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	127,874,745.48	70,992,094.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,546,300.00	2,223,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	126,328,445.48	68,768,794.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,305,091.00	31,607,263.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,959,500.00	762,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,959,500.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	762,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	17,321,590.65
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	17,321,590.65
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,345,591.00	13,523,172.37
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,345,591.00	13,523,172.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(161,652,507.51)	(17,918,767.93)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	642,021,194.62	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	459,058,950.81	

225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	182,962,243.81	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(642,021,194.62)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(803,673,702.13)</u>	<u>(17,918,767.93)</u>

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>509,439,617.53</u>	<u>554,505,072.37</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	99,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	99,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	99,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	99,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	509,340,617.53	554,505,072.37
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	313,766,300.00	382,252,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	313,766,300.00	382,252,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	195,574,317.53	172,252,772.37
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	88,876,900.00	163,650,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	94,588,607.53	3,663,772.37
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,108,810.00	4,939,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>509,439,617.53</u>	<u>553,479,172.37</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	509,439,617.53	553,479,172.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	471,440,767.00	527,521,909.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	159,235,200.00	177,444,725.35
210101	Үндсэн цалин	124,613,200.00	130,204,340.58
210102	Нэмэгдэл	29,096,900.00	43,049,606.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,525,100.00	4,190,778.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,904,500.00	24,499,600.00
210201	Тэтгэврийн даатгал	13,535,000.00	17,240,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,592,400.00	1,814,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,273,900.00	1,451,800.00

210204	Ажилгүйдлийн даатгал	318,500.00	363,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,184,700.00	3,629,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,806,509.00	10,235,303.00
210301	Гэрэл, цахилгаан	1,649,529.00	671,243.00
210302	Түлш, халаалт	8,786,980.00	9,279,060.00
210303	Цэвэр, бохир ус	370,000.00	285,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,688,200.00	14,840,344.00
210401	Бичиг хэрэг	2,808,210.00	579,100.00
210402	Тээвэр, шатахуун	17,791,260.00	12,369,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,279,623.00	1,469,444.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	809,107.00	422,200.00
2105	Нормативт зардал	623,600.00	81,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	623,600.00	81,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,301,600.00	326,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,294,900.00	218,800.00
210604	Урсгал засвар	13,006,700.00	108,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,526,900.00	3,013,800.00
210702	Дотоод албан томилолт	7,526,900.00	3,013,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	225,329,158.00	296,926,437.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	222,950,458.00	295,619,253.00
210803	Даатгалын үйлчилгээ	420,700.00	532,664.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	425,000.00	234,420.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	474,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,025,100.00	153,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,025,100.00	153,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,998,850.53	25,957,263.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,959,500.00	762,500.00

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,959,500.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	762,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,039,350.53	17,321,590.65
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,039,350.53	17,321,590.65
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	7,873,172.37
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		7,873,172.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	1,025,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	1,025,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,025,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,025,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	1,025,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(1,025,900.00)

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,175,118,077.35	89,318,634.89	-114,205,488.39	1,150,231,223.85
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,175,118,077.35	89,318,634.89	-114,205,488.39	1,150,231,223.85
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,175,118,077.35	89,318,634.89	-114,205,488.39	1,150,231,223.85
D01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,175,118,077.35	89,318,634.89	-114,205,488.39	1,150,231,223.85
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,175,118,077.35	89,318,634.89	-114,205,488.39	1,150,231,223.85
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-17,918,767.93	-17,918,767.93
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,175,118,077.35	89,318,634.89	-132,124,256.32	1,132,312,455.92

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН / төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	382,252,300.00	364,930,709.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	382,252,300.00	364,930,709.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	381,489,800.00	364,168,209.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	181,477,200.00	176,664,725.43
210101	Үндсэн цалин	136,357,300.00	129,424,340.66
210102	Нэмэгдэл	39,594,800.00	43,049,606.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,525,100.00	4,190,778.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,499,600.00	24,499,600.00
210201	Тэтгэврийн даатгал	17,240,400.00	17,240,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,814,800.00	1,814,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,451,800.00	1,451,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	363,000.00	363,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,629,600.00	3,629,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,319,900.00	10,235,303.00
210301	Гэрэл, цахилгаан	3,183,300.00	671,243.00
210302	Түлш, халаалт	10,048,900.00	9,279,060.00
210303	Цэвэр, бохир ус	2,087,700.00	285,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,404,700.00	7,404,700.00
210401	Бичиг хэрэг	579,100.00	579,100.00
210402	Тээвэр, шатахуун	5,476,600.00	5,476,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	926,800.00	926,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	422,200.00	422,200.00
2105	Нормативт зардал	181,200.00	81,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	181,200.00	81,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	326,800.00	326,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	218,800.00	218,800.00
210604	Урсгал засвар	108,000.00	108,000.00

2107	Томилолт, зочны зардал	1,398,800.00	1,398,800.00
210702	Дотоод албан томилолт	1,398,800.00	1,398,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	150,728,300.00	143,403,380.92
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	147,470,800.00	141,070,296.92
210803	Даатгалын үйлчилгээ	841,500.00	532,664.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	850,000.00	234,420.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	153,300.00	153,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	153,300.00	153,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	762,500.00	762,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	762,500.00	762,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	762,500.00	762,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	382,252,300.00	364,930,709.35
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	382,252,300.00	364,930,709.35
131001	Улсын төсвөөс санхүүжих	382,252,300.00	364,930,709.35
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	15.00	19.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	14
620003	Үйлчлэх ажилтан	3.00	4

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	192979558.00	172252772.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	192979558.00	172252772.37

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	192979558.00	172252772.37
2104	Хангамж, бараа материалын зардал	6142400.00	19653000.00
210402	Тээвэр, шатахуун	6,142,400.00	19,653,000.00
2107	Томилолт, зочны зардал	2070000.00	2615000.00
210702	Дотоод албан томилолт	2,070,000.00	2,615,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	184767158.00	149,984,772.37
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	184,767,158.00	149,984,772.37
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	7873172.37
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		7873172.37
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	195574317.53	172,252,772.37
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	195574317.53	172,252,772.37
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	88,876,900.00	163,650,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	94,588,607.53	3,663,772.37
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,108,810.00	4,939,000.00

3.АУДИТЫН ТАЙЛАН

3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Хүнс хөдөө аж ахуйн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг газрын дарга Б.Бямбажав танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шатах тослох материалын зарцуулалт, анхан шатны баримтын бүрдүүлэлт, дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх зэрэг алдаа зөрчлүүдэд зөвлөмж өгч менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 20-нөөс 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Б.Бадамцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь салбарын бодлогыг оновчтой хэрэгжүүлэх замаар Мал аж ахуй, газар тариалан, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний цэг салбарыг орон нутагт хөгжүүлэх, салбарын эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, үйлдвэрийг түүхий эдээр, хүн амыг аюулгүй хүнсээр хангахад оршино гэж тодорхойлжээ.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Малын эрүүл мэнд
- Бэлчээр, худаг ус
- Газар тариалан

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт*
- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай*

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хүнс хөдөө аж ахуйн газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

ХХАА-н газрын 2018-2019 оны санхүүгийн баримтад Ховд аймгийн санхүүгийн хяналт, аудитын алба хяналт шалгалт хийж зөрчил илрүүлж акт, албан шаардлага бичигджээ.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоос 570103.9 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 5701.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоос 665763,5 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 6657,6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15764,2 мянган төгрөгөөр буюу 0,9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, өр төлбөр, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Авлага	547.907,4	560.250,8	12.343,3
Бараа материал	69.591,4	96652,5	27.061,0
Үндсэн хөрөнгө	532.732,4	477.563,5	(55.168,8)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,150,231,2	1,134,466,8	-15764,5
Богоно хугацаат өр төлбөр		635,1	635,1
Цэвэр хөрөнгө, өмч	1,150,231,2	1,133,831,7	-16399,5
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,150,231,2	1,134,466,8	-15764,5

Авлага дансны үлдэгдэл 560250,9 мянган төгрөг болж өссөн шалтгаан нь 2009 онд Баялаг буянт ХХК-д ХХААХҮ-ийн яамнаас Жижиг дунд үйлдвэрлэлийн зээл 490000,0 мянган төгрөгийг эргэн төлөлттэй олгож, ХХААГ-ын тайлан тэнцэлд 2012 оноос шилжүүлсэн боловч авлагын эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн, шүүхийн шийдвэр гарсан ч эцэслэн шийдвэрлээгүй, мөн иргэн Н.Булгаад 19121,5 мянган төгрөгийн авлага бүртгэгдсэн байгаа бөгөөд тухайн иргэн 2020 оны 04-р сард нас барсан, 2015 онд Алтай намодис ХХК-д орон нутгийн хөрөнгө оруулалтаар олгогдсон санхүүжилтийн үлдэгдэл 35700,0 мянган төгрөг, төвлөрүүлсэн санхүүжилтийн авлага 5650,0, мянган төгрөгийн, оны эцэст Аж мандал ховд ХХК-д 8260,0 мянган төгрөгийн өвс, тэжээл, нормын хувцасны үнэ шилжүүлж, бараа материалын орлого авахгүйгээр авлага үүсгэсэн байгаа нь авлага бууруулах талаар үр дүнтэй ажил зохион байгуулаагүй, шат дараалсан арга хэмжээ аваагүй, төсвийн хөрөнгийг үр ашиг үр дүнгүй хувь иргэнд ашиглагдсаар байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 96652,5 мянган төгрөг болж 27061,0 мянган төгрөгөөр өссөн нь ХХААЕГ-аас үнэ төлбөргүйгээр шилжүүлэн өгсөн бараа материалаар нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Аудитаар бараа материалын тооллогын бүртгэл, бараа материалын орлого, зарлагын журналаас хөөн хянах боломжгүй байна. Тухайлбал: Бэлтгэн нийлүүлэгчээс авсан шатах тослох материал болон худалдан авсан, зарцуулсан тайлан тооцоог бүрэн бодоогүй, оны эцэст бараа материалын тооллого хийсэн талаарх нотлох баримтгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 855512,5 мянган төгрөг болж 13600,0 мянган төгрөгөөр өссөн нь ХХААЕГ-аас 12500,0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн өгснөөс, 1100,0 мянган төгрөгийн биет бүс хөрөнгө худалдан авч нэмэгдсэн байна.

Хуримтлагдсан элэгдэл оны эхэнд 309180,1 мянган төгрөг байсан тайлант оны элэгдлийн зардал 68768,8 мянган төгрөгөөр нэмэгдэж оны эцэст 377948,9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 635,1 мянган төгрөг болж өссөн нь сэлбэгийн үнэ 444,0 мянган төгрөг, бичиг хэргийн зардлын үнэ 117,0 мянган төгрөг, санхүүгийн программын үнэ 74,1 мянган төгрөг дутуу төлсөнтэй холбоотой нэмэгдэж, барагдуулах боломжтой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1133831,7 мянган төгрөг болж 16399,5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 16399,5 мянган төгрөгийн алдагдалтай гарсан зэргээс шалтгаалж байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилт 68486,0 мянган төгрөгөөр орлого нэмэгдсэн, үнэ төлбөргүй орлого 35601,6 бүгд 93966,3 мянган төгрөгийн орлого өссөн, нэмэлт санхүүжилтийн орлого 10121,3 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт, үнэ төлбөргүй орлого нэмэгдсэн холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 49467,4 мянган төгрөгөөр буюу 0,9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшил, шимтгэлийн зардал 34502,5, хангамж бараа материалын зардал 76217,3 мянган төгрөгөөр тус тус өссөн, бараа үйлчилгээний бусад зардал 10369.6, норматив зардал 3406.3 мянган тогтмол зардал 518,2, томилолтын зардал 4513,1, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 2236,5, мянган төгрөгөөр тус тус буурчээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн нягтлан бодох бүртгэлийн залруулга бичилт хийгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 382252,3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 382252,3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 382252,3 мянган төгрөгийн төсөв батлагдаж 382252,3 мянган төгрөгийг улсын төсвөөс олгохоор баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 382252.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, 382252.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 364930,7 мянган төгрөгийг зарцуулж 17321,6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 364930,7 мянган төгрөг буюу 96.7 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 4812,5, тогтмол зардал 5084,6, норматив зардал 99,6, бараа үйлчилгээний бусад зардал 7324,9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээ 17321.6 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэсэн шалтгаан нь 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотой зарим үйл ажиллагаа явагдаагүйгээс хэмнэгдсэн байна.

Хүснэгт 3	Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт	/мян.төг/
код	хөтөлбөр, арга хэмжээ	мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	17321,6
82518	Хөнөөлт царцаатай тэмцэх зардал	
82542	Монгол мал хөтөлбөр	
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	
	ДҮН	17321,6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн хөгжлийн сангаас Аймгийн засаг даргын 2020 оны 04-р сарын 03-ны А/193 тоот захирамжаар 148000,0, мөн 2020 оны 12-р сарын 22-ны А/826 тоот захирамжаар 4250,0, 2020 оны 12-р сарын 21-ны А/819 тоот захирамжаар 1400,0, 2020 оны 09-р сарын 03-ны А/482 тоот захирамжаар 10000,0, төслөөс 1069,0, нэмэлт сангаас татан төвлөрүүлсэн 2594,8, мянган төгрөг нийт 172252.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс “Шилмэл мал” дэд хөтөлбөрийн хүрээнд Герефорд үүлдрийн өсвөр хээлтүүлэгч худалдан авахад 135000,0, тээврийн зардалд 12760.0, шатахууны зардалд 6893,0, томилолтын зардалд 2615,0, бусад зардалд 1461,6 мянган төгрөгийг зарцуулжээ.

Төсөвт 13523.2 мянган төгрөг төвлөрүүлснээс 5650,0 мянган төгрөгийг буцаан авах авлага үүсгэсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 112 мэдээллээс хугацаандаа оруулсан 75 мэдээлэл, хугацаандаа байршуулдаагүй 4 мэдээлэл, 33 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шилэн дансны мэдээллээс эрсдэлтэй гэж үзсэн гүйлгээг хянахад цалингийн зардлаас бусад 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээг 1-3, 6-12 дугаар саруудад мэдээлээгүй, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, зөвлөмжийг мэдээлээгүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тайланг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 551.3 мянган төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулсан байна. 19121,5 мянган төгрөгийн авлагыг бууруулаагүй 1 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй тул албан шаардлага бичлээ.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 790058.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 99.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулагдаагүй 790058.4 мянган төгрөгийн алдаа зөрчлөөс 99.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 4601.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 733295.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах 2 албан шаардлага бичиж 52161.5 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Мөнгөн гүйлгээний болон үр дүнгийн орлогыг 99.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулж **99,0** мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан албан тоот ирүүлсэн болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 790058.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 4701.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 733196.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

1. Шатахууны тооцоо бодоогүй, Ник ХХК-д шилжүүлсэн дүн, шатах тослох материалын тайлангийн орлого, зарлага зөрүүтэй, орлого, зарлагын баримтаар баталгаажуулахтай холбоотой 1001.8, албан хаагчдад цалингийн урьдчилгаа олгоод суутгаагүй 350.0, ажилчдадаа зах зээлийн үнээс хямд үнээр мал олгоод үнийг нь суутган аваагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй 3200.0, газрын даргын 2020 оны 02-р сарын 20-ны А/9 тоот тушаалаар ахмад настнуудад гарын бэлэг дурсгалын зүйл олгохдоо ашгийн татвар суутган тооцоод татварт шилжүүлээгүй 50.0, мянган төгрөгийн нийт 4601.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14.4.3 дахь заалтад "НББ-д бүх өр төлбөрийг заавал бүртгэнэ", 20-р зүйлийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", гэсэн заалттай нийцээгүй, аудитын "үнэн зөв байдал", "бодитой байх", "эрх ба үүрэг", "иж бүрэн байх", "хэмжилт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт бичих

2. Шилмэл мал дэд хөтөлбөрийн хүрээнд Аймгийн Засаг даргын А/193 тоот захирамжаар аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр "Герефорд" үүлдрийн өсвөр хээлтүүлэгчийг 148000.0 мянган төгрөгөөр худалдан авахдаа тендер зарлаагүй, шууд гэрээ байгуулсан, үржлийн мал амьтныг үндсэн хөрөнгөд бүртгээгүй, өсвөрийн хээлтүүлэгчийг Сэлэнгэ аймгаас авч ирэх шатахууны болон тээврийн зардал, бусад холбогдох зардлуудыг шингээж бүртгээгүй, мөн Сэлэнгэ үүлдрийн 24000.0 мянган төгрөгийн хээлтүүлэгч малыг үнэ төлбөргүй хүлээн авсан холбогдох албан тушаалтны шийдвэргүйгээр сумдад хуваарилан олгосонтой холбоотой нийт 180114.6 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 6.4.4.хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох заалтуудыг, 24.4-д төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", 41.2.3."төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах, УСНББОУС 17-д 31.а-д Үндсэн хөрөнгийн барьж байгуулах буюу худалдан авахтай шууд холбогдон гарсан зардал, б.-д газар талбайг бэлтгэх зардал, в-д анхны хүргэлт ба ачиж буулгах зардал, г-д суурилуулалт ба угсралтын зардал үндсэн хөрөнгийн өртөгт орно, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27.1. Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр концессийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 7.1-д Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг

баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна: 7.1.1.нээлттэй тендер шалгаруулалтын журам; 7.1.2.тендер шалгаруулалтын онцгой журам; гэсэн заалттай нийцээгүй, аудитын “үнэн зөв байдал”, “бодитой байх”, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх”, “хэмжилт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага бичигдлээ.

2. Авлага бууруулаагүй, өмнөх оны зөвлөмж хэрэгжүүлээгүй, авлага бууруулах талаар ямар нэгэн арга хэмжээ авч ажил зохион байгуулаагүйн зэрэгцээ авлагыг өсгөсөн 553061.5 мянган төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага бичлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, НББ-ийн тухай хуулийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, гэсэн заалттай нийцээгүй, аудитын “үнэн зөв байдал”, “бодитой байх”, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх”, “хэмжилт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага бичигдлээ

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 4 алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

а. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

2. Дараагийн аудитаар цалин, НДШ, ХХОАТ-ын тооцоог, үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд сорил хэрэгжүүлэх цаг хугацаа хүрэлцэхгүй байсан тул дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Дотоод хяналт хариуцсан албан тушаалтан ажиллаж байгаа ч хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээ байхгүй, санхүүгийн ил тод мэдээлэл хангагдаагүй, аудитаар санхүүгийн тайлангаар материаллаг алдаа зөрчил илэрч, дотоод хяналт хэрэгжээгүй байна. Зөрчлийн нэгтгэлд дурдсан болон анхаарах хандуулахуйц асуудлын хэсэгт бичсэн алдаа зөрчилд дахин хяналт, шалгалт хийх шаардлагатай байна.
- 1.2. Эрсдэл: Дотоод хяналтын алба дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байх, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, завших, дутах,
- 1.3. Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 311 дүгээр тогтоолын 1.5-д “энэ журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө”, 3.5-д “дотоод хяналт

шалгалтын нэгж, ажилтан нь хяналтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд 1 доошгүй удаа тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлнэ”, 3.6-д “дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ” гэсэн заалтуудыг мөрдөөгүй тул дотоод хяналтын баг томилон дээрх алдаа арилгуулан ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. И баримтын бүрдүүлэлт

2.1. Илрүүлэлт: Эд хариуцагч нь тухайн сард худалдан авсан болон зарцуулсан шатах тослох материалын тайлангаа авсан шатахуундаа тааруулан тайлан гаргадаг, Газрын дарга нь өөрөө шатахуун олгох зөвшөөрлийн бичгийг олгодог, тухайн сарын эцэст эд хариуцагч нь жолооч бүрээр олгосон шатахууны зардал бичдэг, Бараа материал худалдан авахдаа И баримт авахгүйгээр худалдан авдаггүй 14761,4 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Мөн 2020 оны 12.16-ны А/55 тоот тушаалаар ажилчдадаа түлээ нүүрсний хөнгөлөлт олгохдоо 2020 оны 12-р сарын 21-ны 211 тоот төлбөрийн хүсэлтээр Би Эм Жи Юу ХХК-ны 5002712005 тоот дансанд 9900.0 мянган төгрөг шилжүүлж бэлнээр авч ажилчдадаа олгосон байна.

2020 оны 09-р сард ЗДТГ-т бүртгэлтэй, Булган сум дахь Улсын нөөцийн салбарт хадгалагдаж байсан 27500.0 мянган төгрөгийн өвсийг орлого авхуулаад, буцааж ЗДТГ-т зарлага гаргасан, уг өвсийг ЗДТГ нь Өвөрхангай аймгийн ЗДТГ-т зарлага гаргасан, нийт 52151.4 мянган төгрөгийн зөрчил нь аудитын “үнэн зөв байдал”, “бодитой байх”, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх”, “хэмжилт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эрсдэл: Холбогдох хууль тогтоомжийг баримтлах, зардлыг нотлохгүй байх

Өгсөн зөвлөмж Энэ нь Үнэн зөв байдал, Хэмжилт, Иж бүрэн байх зэрэг_батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, НББ-ийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.5 дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, 13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	ХХАА-н газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
--------	--------------	--	--------------

2021

ХОА-2021/94/СТА-ТШЗ

Шалгагдсан
байгууллагын нэр:

Хүнс, хөдөө аж ахуйн газар

Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шатахууны тооцоо бодоогүй, Ник ХХК-д шилжүүлсэн дүн, шатах тослох материалын тайлангийн орлого, зарлага зөрүүтэй, орлого, зарлагын баримтаар баталгаажаагүй, албан хаагчдад цалингийн урьдчилгаа олгоод суутгаагүй, ажилчдадаа зах зээлийн үнээс хямд үнээр мал олгоод үнийг нь суутган аваагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй, газрын даргын 2020 оны 02-р сарын 20-ны А/9 тоот тушаалаар ахмад настнуудад гарын бэлэг дурсгалын зүйл олгохдоо ашгийн татвар суутган тооцоод татварт шилжүүлээгүйтэй холбоотой 4601,8 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.	4601,8	Төлбөрийн акт	дарга , ня- бо	Б.Бямбажав Д.Батбаатар
2	- Шилмэл мал дэд хөтөлбөрийн хүрээнд Аймгийн ЗД-ын 2020 оны 04 дүгээр сарын 03-ны А/193 тоот захирамжаар Герефорд үүлдрийн өсвөр хээлтүүлэгч худалдан авах 148000.0 сая төгрөгийн бух худалдан авах ажиллагааг тендер зарлаагүй, үржлийн мал амьтныг үндсэн хөрөнгөд бүртгэнэ гэж заасны дагуу хөрөнгөд бүртгээгүй, шууд гэрээ байгуулсан, өсвөрийн хээлтүүлэгчийг авчрах тээвэр шатахууны зардал, холбогдох зардлуудыг шингээж бүртгээгүй, сумдад хуваарилж өгсөн, сумдууд орлого аваагүйтэй, - Үнэ төлбөргүй ирсэн Сэлэнгэ үүлдрийн хээлтүүлэгчийг сумдад зөвшөөрөлгүй олгосон	180114,6	Албан шаардлага	дарга , ня- бо	Б.Бямбажав Д.Батбаатар
3	Мөнгөн гүйлгээ, үр дүнгийн тайлангийн орлого алдаатай илэрхийлсэн	99,0	Залруулга хийх	дарга , ня- бо	Б.Бямбажав Д.Батбаатар
4	Авлага бууруулаагүй, өмнөх оны зөвлөмж хэрэгжүүлээгүй, авлага бууруулах талаар ямар нэгэн арга хэмжээ авч ажил зохион байгуулаагүйн зэрэгцээ авлагыг өсгөсөн	553081,5	Албан шаардлага	дарга , ня- бо	Б.Бямбажав Д.Батбаатар
5	Дотоод хяналт хариуцсан албан тушаалтан ажиллаж байгаа ч хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээ байхгүй, аудитаар алдаа зөрчил илэрч, дотоод хяналт хэрэгжээгүй байна.	0	Зөвлөмж өгөх	Дарга, нябо	Б.Бямбажав Д.Батбаатар

6	<ul style="list-style-type: none"> - Эд хариуцагч нь тухайн сард худалдан авсан болон зарцуулсан шатах тослох материалын тайлангаа авсан шатахуундаа тааруулан тайлан гаргадаг, Газрын дарга нь өөрөө шатахуун олгох зөвшөөрлийн бичгийг олгодог, тухайн сарын эцэст эд хариуцагч нь жолооч бүрээр олгосон шатахууны зардал бичдэг, - и баримтын бүрдэл дутуу - 2020 оны 12.16-ны А/55 тоот тушаалаар ажилчдадаа түлээ нүүрсний хөнгөлөлт олгохдоо 2020 оны 12-р сарын 21-ны 211 тоот төлбөрийн хүсэлтээр Би Эм Жи Юу ХХК-ны 5002712005 тоот дансанд 9900.0 мянган төгрөг шилжүүлж бэлнээр авч ажилчдадаа олгосон - 2020 оны 09-р сард ЗДТГ-т бүртгэлтэй, Булган сум дахь Улсын нөөцийн салбарт хадгалагдаж байгаа өвсийг орлого авхуулаад буцааж ЗДТГ-т зарлага гаргасан нь уг өвсийг ЗДТГ нь Өвөрхангай аймгийн ЗДТГ-т зарлага гаргасан орлого авах шаардлагагүй, 	52161,4	Зөвлөмж өгөх	Дарга, ня-бо	Б.Бямбажав Д.Батбаатар
ДҮН		790058,4			

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР****Х.БОЛДБААТАР****Огноо:2021. 02.25****АУДИТЫН МЕНЕЖЕР****А.ЦЭЦЭГСҮРЭН****Огноо: 2021. 02.25****БЭЛТГЭСЭН:****ГЭРЭЭТ АУДИТОР****Б.БАДАМЦЭЦЭГ****Огноо: 2021. 02.25**